

# ТОЙМ

---



**ОЛОН УЛСЫН  
ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ**

2024.07.01

*Голомт Капитал ҮЦК-д бэлтгэв*

Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

ТОВЧ

- S&P500 индексийн хувьд 5460-5500 ханшийн хооронд голлох арилжаанууд хийгдлээ.
- Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчдийн мэтгэлцээн, технологийн компаниудын өндөр өсөлт болон бодлогын хүүгийн шийдвэрүүд зэрэг нь хөрөнгө оруулагч нарын шийдвэргүй байдалд нөлөөлсөн хэвээр байна.
- Хятадын PMI индекс 2 сар дараалж тааруу гарлаа.
- Томоохон аж үйлдвэрийн компаниуд ашигт ажиллагаа 4 дүгээр сарын түвшин болох 4%-иас багасаж 5 дугаар сард 0.7%-д хүрээд байна.
- Хятадын гадаадын хөрөнгө оруулагчдын гарах урсгал үргэлжилж байна.

2024 он 6-р сарын 28

Dow Jones	39,118.86
S&P 500	5,460.48
Nasdaq	17,723.83
DAX	18,234.12
FTSE 100	8,164.12
S&P/ASX 200	7,740.30
HANG SENG	17,722.32

АНУ-ын индексийн өгөөж

Индекс	Өдрийн	Долоо хоног	Сар	Жилийн эхнээс	Жил	3 жил
Dow Jones	-0.12%	-0.74%	1.12%	3.79%	13.69%	12.45%
S&P 500	-0.41%	0.23%	3.47%	14.48%	22.7%	25.46%
Nasdaq	-0.76%	1.28%	5.91%	18.07%	28.55%	21.07%

2024 оны 7 сарын 1-ний 11:30



Европын индексийн өгөөж

Индекс	Өдрийн	Долоо хоног	Сар	Жилийн эхнээс	Жил	3 жил
DAX	0.13%	-0.5%	1.43%	8.85%	12.92%	16.51%
FTSE 100	0.19%	1.42%	1.34%	5.57%	8.40%	14.61%

2024 оны 7 сарын 1-ний 11:30



Ази Номхон далайн индексийн өгөөж

Индекс	Өдрийн	Долоо хоног	Сар	Жилийн эхнээс	Жил	3 жил
S&P/ASX 200	-0.32%	0.11%	0.53%	2.00%	7.48%	5.94%
Hang Seng	0.03%	-1.69%	-1.98%	3.96%	-6.31%	-37.40%

2024 оны 7 сарын 1-ний 11:30





## Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

### Голлох индексүүд ханшийн тодорхойгүй байдлыг үүсгэлээ

S&P 500 индексийн хувьд 5460-5500 ханшийн хооронд голлох арилжаанууд хийгдсэн бөгөөд баасан гарагийн арилжаа нээгдэх үед өмнөх долоо хоногийн дээд ханшийг эвдсэн ч 1.3 хувийн уналтыг үзүүлэн хаагдлаа. Мөн бусад индексүүдийн хувьд чиглэлгүй байдлыг үүсгэн зах зээл дээр хүлээлтийн байдал үүсээд байна. Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчдийн мэтгэлцээн, технологийн компаниудын өндөр өсөлт болон бодлогын хүүгийн шийдвэрүүд зэрэг нь хөрөнгө оруулагч нарын шийдвэргүй байдалд нөлөөлсөн хэвээр байна.

### PCE инфляц өмнөх сараас буурахын сацуу орон сууцны борлуулалт буураад байна

Хүнсний болон эрчим хүчний салбарын үнийг тооцохгүй гаргадаг хувийн хэрэглээний зардлын 5 сарын инфляц болох PCE хүлээлтийн дагуу буюу 0.1 хувь гарсан юм. Уг үзүүлэлт нь 4-р сард 0.3 хувь байсан бөгөөд инфляцын хурд буурч байгааг харуулж байна. Энэ нь мэдээж 9-р сард ХНС бодлогын хүүгээ бууруулах магадлал өндөр байгааг харуулж байна.

Үүний зэрэгцээ 5-р сарын шинэ орон сууцны борлуулалт хүлээлтээс бага гарч сүүлийн 6 сарын турш борлуулалт эрчимтэй буурч байна. АНУ-ын 30 жилийн хугацаатай орон сууцны зээлийн дундаж хүү 6.87 хувьд хүрч сүүлийн 10 жилд байгаагүй дээд хэмжээнд хүрсэнтэй холбогдуулан барилгын салбарын уналт үүсэж болзошгүй байна.

### Онцлох хувьцаануудын уналт үргэлжилсээр байна

Nvidia компанийн гүйцэтгэх захирал Jensen Huang болон дэд ерөнхийлөгч Colette Kress нар ойролцоогоор 53 сая ам.долларын (NVDA) хувьцаагаа заржээ. Уг явдалтай зэрэгцэн ханш 6 орчим хувийн уналтыг үзүүлж, хүчтэй өсөлтийг үүсгээд байсан хувьцаанд засвар хөдөлгөөн орж ирж байна. Өнгөрөгч баасан гарагт Nike компанийн хувьцааны үнэ 20 хувиар унасан нь түүхэнд байгаагүй нэг өдрийн доторх томоохон уналт болоод байна. Нэгж хувьцааны үнэ 95 ам.доллароос 73 ам.доллар хүртэл унасан нь тус компанийн зах зээлийн үнэлгээг 28.41 тэрбум ам.доллароор бууруулсан. Тус уналт 2025 оны төсөвлөгдсөн орлого 10 хүртэлх хувиар буурна гэсэн мэдэгдлээс шалтгаалжээ.

### График 1: АНУ-ын S&P500 индексийн ханшийн таамаглал

abliguun published on TradingView.com, Jul 01, 2024 14:58 UTC+8  
S&P 500 E-mini Futures, 1D, CME +17.50 (+0.32%) +17.50 (+0.32%)







## Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

### БНХАУ-ын зах зээл өнгөрсөн долоо хоногт уналттай хаагдлаа

Хятадын эдийн засгийн өсөлтийн удаашралт нь хөрөнгө оруулагчдын эрсдэл хүлээх чадварыг хумьж хөрөнгийн зах зээлийн уналтад нөлөөлж байна. Энэ долоо хоногт Shanghai Composite индекс болон цэнхэр чипний (blue chip) CSI 300 индекс бага зэрэг унасан үзүүлэлттэй байгаа бол Hang Seng индекс 1.5%-иар унажээ.

### Аж үйлдвэрлэлийн компаниудын ашгийн өсөлт удааширлаа

Үндэсний статистикийн хорооны тайланд мэдээлсэнээр томоохон аж үйлдвэрийн компаниуд ашигт ажиллагаа 4 дүгээр сарын түвшин болох 4%-иас багасаж 5 дугаар сард 0.7%-д хүрээд байна. Шинжээчид уул уурхайн компаниудын орлого болон ашгийн өсөлтийг түүхий эдийн үнийн өсөлттэй холбон тайлбарлажээ.

### PMI индекс 2 сар дараалж тааруу гарлаа

Гэвч, Хятадын орон сууцны уналт, үргэлжилсэн үнийн уналтын дарамт болон хэрэглээний зарцуулалтын удаашралт нь сар ирэх тусам зах зээл уналттай байгааг харуулж байна. Хөрөнгө оруулагчид энэ долоо хоногийн Ням гарагт гарах Хятадын албан ёсны худалдан авалтын менежерийн индекс (PMI) болон Caixin-аас мэдээллэх хувийн салбарын үйлдвэрийн судалгааны тайланд анхаарал хандуулж байна.

### Гадаадын хөрөнгө оруулагчдын гарах урсгал үргэлжилж байна

Энэ долоо хоногийн хөрөнгийн зах зээлийн уналтад гадаад худалдаа мөн нөлөөлжээ. Bloomberg-ийн мэдээллэж байгаагаар Хятад өөрийн гадаад хөрөнгийн сангаас 49.4 тэрбум юань бүхий оншор хувьцааг Хонг Конгийн арилжааны замаар өнгөрөгч Лхагва гарагт зарсан нь 1 дүгээр сараас хойши анхны хөрөнгийн гадагшаа чиглэсэн урсгал боллоо. Гадаад хөрөнгө оруулагчдад дараах шалтгаануудын улмаас хувьцаагаа зарах дарамт үүсээд байна. Үүнд: Хятадын олон компаниудын тайлан хүлээлтээс доогуур байсан, эдийн засгийн өсөлтийн хэтийн төлөв сул хэвээр байгаа нь нөлөөлжээ.

### График 2: Hang-Seng индексийн ханшийн таамаг

abillguun published on TradingView.com, Jun 24, 2024 14:53 UTC+8

Hang Seng Index Futures, 1D, HKEX O18,017 H18,057 L17,778 C17,880 -138 (-0.77%)



## БИДНИЙ АЖИГЛАЛТАД БУЙ ХУВЬЦААНУУД

**График 3: CVS компанийн техник шинжилгээ**



CVS Health Corp. нь АНУ-ын томоохон эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгч компани юм. Энэхүү компани нь 1963 онд Массачусеттс мужид ах дүү Голдштайн болон Ральф Хоагланд нараар үүсгэн байгуулагдсан байна.

**График 4: BWA компанийн техник шинжилгээ**



BorgWarner Inc. АНУ-д төвтэй дэлхийн томоохон автомашины эд анги борлуулагчдын нэг юм. Компанийн үйлчлүүлэгчдийн дотор Ford, General Motors, Volkswagen болон Stellantis зэрэг үйлдвэрлэгчид ордог бөгөөд тэдгээр нь өөрсдийн загварын цахилгаан автомашин хөгжүүлэлтэнд хөрөнгө оруулж байна.